# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН 2023 ОНЫ ТАЙЛАН

2023.10.15

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргаар 2023 онд хийх дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөнд 8 хяналт хийхээр төлөвлөсөн.

2023 оны 10 сарын 15-ны байдлаар 6 удаа дотоод хяналт хийсэн.

Зөвлөмжийн тоо, хэрэгжилт: 12 зөвлөмж, хэрэгжилт 95 хувь

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ: 4

Дотоод хяналт шалгалтын удирдамжийг газрын даргаар батлуулан, дотоод хяналтын тайланг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулсан.

Хяналт шалгалтыг ярилцлага, баримт бичгүүдийг үзэж танилцах, зөвлөн туслах, холбогдох баримтуудыг татан авч үзэж шинжлэх зэрэг арга зүйг ашигласан.

## 1. Төрийн албан хаагчдын төлөвлөлт, ажлын зохион байгуулалтанд хийсэн дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчид, сумын байгаль хамгаалагч

Хяналт шалгалтанд газрын нийт 4 мэргэжилтэн, нягтлан бодогч, 2 байгаль хамгаалагч хамрагдсан.

Хяналт шалгалтыг ярилцлага, баримт бичгүүдийг үзэж танилцах, зөвлөн туслах, холбогдох баримтуудыг татан авч үзэж шинжлэх зэрэг арга зүйг ашигласан.

Албан хаагчдын бичиг баримтын эмх цэгц, төлөвлөлтийг 4 үзүүлэлтээр 1-5 оноогоор үнэлсэн. Нийт 20 оноо авна.

| № | Нэрс | Албан тушаал | Төлөвлөлт | Бичиг баримтын эмх цэгц | | Бодлогын бичиг баримтуудыг хяналтанд авсан | Авсан оноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хууль, журмын | Судалгаа, мэдээллийн сан | | |
| 1 | Ц.Цэрэнчимэд | Нягтлан бодогч | - | 5 | 5 | 5 | 15 |
| 2 | Э.Дашжаргал | Аялал жуулчлал, тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн | 4 | 2 | 2 | 2 | 10 |
| 3 | М.Номинзул | Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн | 4 | 2 | 2 | 2 | 10 |
| 4 | Н.Намуунцэцэг | Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн | 4 | 3 | 3 | 3 | 13 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Н.Маралгуа | Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн | 4 | 3 | 3 | 3 | 13 |
| 6 | С.Түмэндэлгэр | Сүмбэр сумын байгаль хамгаалагч | 3 | | | | 3 |

Төрийн албан хаагчдын төлөвлөлтөнд дараах нийтлэг алдаа байна.

1. Зарим арга хэмжээг хэт ерөнхий төлөвлөсөн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 5 дугаар хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын 1.1. "Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ"-г хэрэгжүүлэх зорилгоор тухайн албан хаагч гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлохдоо дараах арга зүйг мөрдлөг болгоно. Үүнд: 1.1.2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ижил нэршилтэй, ижил утгатай, бие биеэ агуулсан утгатай зорилт, арга хэмжээг нэгтгэж, нэг арга хэмжээ болгон тодорхойлох; 1.1.3. Гүйцэтгэлийн зорилт болон зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдааг хангах; гэж заасныг баримтлан төлөвлөсөн.

Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг улирлаар тодорхойлсон.

Дээрх зааврыг уншиж тайлагналтаа сайжруулах шаардлагатай.

Албан хаагч бүрээр танилцуулга, зөвлөмж гаргасан.

1. Бодлогын бичиг баримт, төлөвлөгөөний зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт тус бүрт тохирсон үр дүнг тайлагнах. Зарим үйл ажиллагаа, шалгуурыг орхихгүй байх.
2. Хариуцсан чиг үүргийн хүрээнд санаачилгатай ажиллах, шинэлэг үйл ажиллагаа зохион байгуулж тайлагнах
3. Иргэд, олон нийтийн байгаль орчны салбарын мэдлэг, экологийн боловсролыг дээшлүүлэх, оролцоог нэмэгдүүлэх
4. Зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг бичих. Зохион байгуулсан үйл ажиллагааг тоочиж бичихээсээ илүү арга хэмжээ зохион байгуулаад хүрсэн үр дүн. Тухайлбал: сургалт зохион байгуулж, гарын авлага тарааж, зөвлөгөөн зохион байгуулснаар ИЙМ ҮР ДҮНД ХҮРСЭН гэх мэт
5. Найруулга сайтай, үг үсгийн алдаагүй, үнэн зөв, товч тодорхой, тоо хэмжээтэй, өмнөх оны мөн үетэй харьцуулсан, ахиц өөрчлөлтийг хэмжсэн, зурагтай, бүрэн тайлагнах
6. Зохион байгуулсан ажлын тайланг дууссан тухай бүр хурдан гаргах, цахимд байршуулах

## 2. Төрийн албан хаагчдын тайлагналтанд хийсэн дотоод хяналт.

2022 оны эхний хагас жилийн байдлаар: Хэрэгжилт, хяналтанд авсан байдал:

| № | Албан хаагчийн нэр | ЗДҮАХ-ийн хяналтанд авсан арга хэмжээний тоо | ЗГҮАХ-ийн хяналтанд авсан арга хэмжээний тоо |
|---|---|---|---|
| 1 | Б.Гандулам | 11 | |
| 2 | Хүрээлэн буй орчны бохирдол | 5 | 2 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | М.Номинузл | 5 | 1 |
| 4 | Э.Дашжаргал | 7 | 1 |
| 5 | Н.Намуунцэцэг | 4 | 3 |
| 6 | С.Саранчимэг | 1 | |
| 7 | Ц.Цэрэнчимэд | 1 | |
| | **Нийт** | 32 | 7 |
| | **Үнэлгээ /эхний хагас жил/** | 75 | 78 |

1. Бодлогын баримт бичгүүдтэй бүрэн танилцаж, БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ
2. Бодлогын бичиг баримт, төлөвлөгөөний зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур тус бүрт тохирсон үр дүнг тайлагнах. Зарим үйл ажиллагаа, шалгуурыг орхиж тайлагнахгүй байх.
3. Хариуцсан чиг үүргийн хүрээнд санаачилгатай ажиллах, шинэлэг үйл ажиллагаа зохион байгуулах
4. Найруулга сайтай, алдаагүй, үнэн зөв, товч тодорхой, бүрэн тайлагнах

## 3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн дотоод хяналт

Хяналт шалгалтыг https://shilendans.gov.mn/login сайтанд байршуулсан мэдээллийг хянах, тулгах, тайлбар авах арга зүйгээр хийсэн

Дотоод хяналт шалгалт хийх үндэслэл:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол.

Байгууллагын шилэн дансны цахим хуудас нь :

1. Төсөв/ гүйцэтгэл
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт
3. Бусад гэсэн гурван дэд цэстэй.

**1. Төсөв/ гүйцэтэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан 2 дүгээр улиралд хамаарах дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан.





Говьсүмбэр аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар

И-мэйл:
Ажлын утас: 70543063
Шуудангийн хаяг: -
Сошиал хаяг:
Дэлгэрэнгүй харах

Төсвийн байгууллага

Төсөв, гүйцэтгэл | Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт | Бусад

Тайлант он: 2023

| № | Тайлангийн нэр | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хугацаа | Заавал эсэх | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Сар бүр | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | Төлөвлөгөө | 7 хоногийн дотор | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ⊕ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ |
| 2 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал | Гүйцэтгэл | дараа сарын 8-ны дотор | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ |
| 3 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Хөтөлбөр, зориулалт | Гүйцэтгэл | дараа сарын 8-ны дотор | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ | ⊖ |
| | Хагас жил бүр | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Санхүүгийн тайлан | Гүйцэтгэл | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | * | | | | | | ⊖ | | | | | | ⊖ |



Мэдээллийн нэр: **Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал**
Давтамж: **Сар бүр**
Мэдээллийн төрөл: **Гүйцэтгэл**
Мэдээлэл оруулах хугацаа: **2023-02-08**
Тайлант үе: Он: **2023** Улирал: **1** Сар: **1-р сар** Мэдээлэл оруулсан огноо: **2023-02-07**

Тайлан | Хавсаргасан файл

| № | Данс | ЭЗА код | Эдийн засгийн ангилал | Батлагдсан төсөв жилээр | Батлагдсан төсөв тайлант үе /өссөн дүнгээр/ | Батлагдсан төсвийн гүйцэтгэл /өссөн дүнгээр/ | Батлагдсан төсөв тайлант үе /цэвэр дүнгээр/ | Батлагдса | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 100220013001 | 2 | НИЙТ ЗАРЛАГЫН БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 527,295,700.00 ₮ | 30,702,100.00 ₮ | 22,910,541.36 ₮ | 30,702,100.00 ₮ | | |
| 2 | 100220013001 | 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 527,295,700.00 ₮ | 30,702,100.00 ₮ | 22,910,541.36 ₮ | 30,702,100.00 ₮ | | |
| 3 | 100220013001 | 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 525,295,700.00 ₮ | 30,202,100.00 ₮ | 22,910,541.36 ₮ | 30,202,100.00 ₮ | | |
| 4 | 100220013001 | 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 242,837,900.00 ₮ | 19,460,800.00 ₮ | 19,323,204.79 ₮ | 19,460,800.00 ₮ | | |
| 5 | 100220013001 | 210101 | Үндсэн цалин | 114,000,000.00 ₮ | 9,500,000.00 ₮ | 10,212,221.00 ₮ | 9,500,000.00 ₮ | | |
| 6 | 100220013001 | 210102 | Нэмэгдэл | 105,600,000.00 ₮ | 8,800,000.00 ₮ | 8,626,983.79 ₮ | 8,800,000.00 ₮ | | |
| 7 | 10022001300 | 210103 | Урамшуулал | 17,737,900.00 ₮ | 660,800.00 ₮ | | 660,800.00 ₮ | | |

| Мэдээлэл | Оруулах хугацаа | Оруулсан хугацаа |
|---|---|---|
| Төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээ /1-4 сар/ | Дараа сарын 08-ны дотор | 1 сарын мэдээ-2 сарын 7 /засварласан /<br>2 сарын мэдээ-3 сарын 3<br>3 сарын мэдээ-4 сарын 7<br>4 сарын мэдээ-5 сарын 8 |

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл хугацаанд нь байршуулсан.

**Говьсүмбэр аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар**

**И-мэйл:**
**Ажлын утас:** 70543063

**Шуудангийн хаяг:** -
**Сошиал хаяг:**

Дэлгэрэнгүй харах

**Тайлант үе:** Он: **2023** Улирал: **1** Сар: **3-р сар** Мэдээлэл оруулсан огноо: **2023-04-07**

| № | Үзүүлэлт | Эхлэх огноо | Дуусах огноо | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Тухайн жилийн төсөв | Тухайн жилийн санхүүжилт (Өссөн дүнгээр) | Зөрүү | Үүсгэсэн огноо | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мод тарих сургалт-Гэрээгээр | 2023-03-25 | 2023-03-26 | 500,000.00 ₮ | 500,000.00 ₮ | 500,000.00 ₮ | | 500,000.00 ₮ | 2023-04-07 | ✓ |
| 2 | Биотехникийн арга хэмжээ-Тушаалаар | 2023-03-13 | 2023-05-15 | 690,600.00 ₮ | | 690,600.00 ₮ | 587,000.00 ₮ | 103,600.00 ₮ | 2023-04-07 | ✓ |

Нэр томъёон

**Говьсүмбэр аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар**

**И-мэйл:**
**Ажлын утас:** 70543063

**Шуудангийн хаяг:** -
**Сошиал хаяг:**

Дэлгэрэнгүй харах

| № | Үзүүлэлт | Эхлэх огноо | Дуусах огноо | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Тухайн жилийн төсөв | Тухайн жилийн санхүүжилт (Өссөн дүнгээр) | Зөрүү | Үүсгэсэн огноо | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж болон улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн, орчны бусийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох арга хэмжээ Мод тарих сургалт-Гэрээгээр | 2023-03-25 | 2023-03-26 | 500,000.00 ₮ | 500,000.00 ₮ | 500,000.00 ₮ | 500,000.00 ₮ | | 2023-05-01 | ✓ |
| 2 | Биотехникийн арга хэмжээ-Тушаалаар | 2023-03-13 | 2023-05-15 | 690,600.00 ₮ | | 690,600.00 ₮ | 690,600.00 ₮ | | 2023-05-01 | ✓ |
| 3 | Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, байгалийн ойн санд шинэ тарилт хийх нөхцөл бүрдүүлэх | 2023-04-10 | 2023-04-25 | 28,702,000.00 ₮ | 28,500,000.00 ₮ | 28,702,000.00 ₮ | 19,950,000.00 ₮ | 8,550,000.00 ₮ | 2023-05-01 | ✓ |

| **Хугацаа** | **Батлагдсан төсөв** | **Санхүүжилт** | **гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| Төлөвлөгөө гүйцэтгэл 2023 он 1 сар | 527,295,700.00 | 30,702,100.00 | 22,910,541.36 |
| Төлөвлөгөө гүйцэтгэл 2023 он 2 сар | 527,295,700.00 | 66,103,300.00 | 44,753,551.41 |
| Төлөвлөгөө гүйцэтгэл 2023 он 3 сар | 527,295,700.00 | 101,092,000.00 | 69,124,810.35 |
| Төлөвлөгөө гүйцэтгэл 2023 он 4 сар | 527,295,700.00 | 162,797,600.00 | 113,151,805.85 |

# Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээлэл

**Говьсүмбэр аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар**

**И-мэйл:**
**Ажлын утас:** 70543063

**Шуудангийн хаяг:** -
**Сошиал хаяг:**

Дэлгэрэнгүй харах

Мэдээллийн нэр: **Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл**

Давтамж: **Сар бүр**

Мэдээлэл оруулах хугацаа: **2023-04-08**

Мэдээллийн төрөл: **Гүйцэтгэл**

**Тайлант үе:** Он: **2023** Улирал: **1** Сар: **3-р сар** Мэдээлэл оруулсан огноо: **2023-04-07**

| № | Үзүүлэлт | Эхлэх огноо | Дуусах огноо | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Тухайн жилийн төсөв | Тухайн жилийн санхүүжилт (Өссөн дүнгээр) | Зөрүү | Үүсгэсэн огноо | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мод тарих сургалт-Гэрээгээр | 2023-03-25 | 2023-03-26 | 500,000.00 ₮ | 500,000.00 ₮ | 500,000.00 ₮ | | 500,000.00 ₮ | 2023-04-07 | ✓ |
| 2 | Биотехникийн арга хэмжээ-Тушаалаар | 2023-03-13 | 2023-05-15 | 690,600.00 ₮ | | 690,600.00 ₮ | 587,000.00 ₮ | 103,600.00 ₮ | 2023-04-07 | ✓ |

| № | Үзүүлэлт | Эхлэх огноо | Дуусах огноо | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Тухайн жилийн төсөв | Тухайн жилийн санхүүжилт (Өссөн дүнгээр) | Үүсгэсэн огноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж болон улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн, орчны бусийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох арга хэмжээ Мод тарих сургалт-Гэрээгээр | 2023.03.25 | 2023.03.26 | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 2023.05.01 |
| 2 | Биотехникийн арга хэмжээ-Тушаалаар | 2023.03.13 | 2023.05.15 | 690,600.00 | | 690,600.00 | 690,600.00 | 2023.05.01 |
| 3 | Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, байгалийн ойн санд шинэ тарилт хийх нөхцөл бүрдүүлэх зорилгоор шинээр ойжуулах талбайн хамгаалалтын хашаа барих 3 га /Хэрлэн гол дагуу/ | 2023.04.10 | 2023.04.25 | 28,702,000.00 | 28,500,000.00 | 28,702,000.00 | 19,950,000.00 | 2023.05.01 |
| 4 | Хууль бус ан агнуур, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулах | 2023.04.01 | 2023.05.31 | 1,700,000.00 | | 1,700,000.00 | 1,700,000.00 | 2023.05.01 |
| 5 | Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж болон улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн, орчны бусийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох арга хэмжээ - Сургагч багш нарын байрны зардал | 2023.02.01 | 2023.02.28 | 140,000.00 | | 140,000.00 | 140,000.00 | 2023.05.01 |
| 6 | Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж болон улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн, орчны бусийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох арга хэмжээ -"Зөв дадал, зэрэг өөрчлөлт, ногоон ирээдүй" аян Эко өртөө арга хэмжээ | 2023.04.01 | 2023.05.31 | 1,333,000.00 | | 1,333,000.00 | 113,000.00 | 2023.05.01 |

**БУСАД**

| № | Эцэг/эхийн нэр, нэр | Байгууллага, Албан тушаал | Тайлбар | Мэдэгдэл гаргасан огноо | Зөрчил үүссэн эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Д.Мөнх-Эрдэнэ | Газрын дарга | Ховд аймгийн Булган голын алим ХХК-наас алимны мод тарих аргачлалын сургалт авах гэрээ | 2023.03.24 | Үгүй |
| 2 | Д.Мөнх-Эрдэнэ | Газрын дарга | Хэрлэн гол дагуу ойжуулах талбайн хашаа барих ажлын гэрээ Жавхлант аривжих ХХК-ны захирал Б.Баттүвшин | 2023.04.10 | Үгүй |
| 3 | Д.Мөнх-Эрдэнэ | Газрын дарга | Монгол даатгал ХХК салбарын төлөөлөгч Б.Сугармаа | 2023.04.20 | Үгүй |

Холбогдох шийдвэрүүдийг хугацаанд нь оруулсан.

**ДҮГНЭЛТ:** Шилэн дансны цахим мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хүрээнд үзэхэд 3 бүлэгт 55 мэдээллийг хугацаанд нь оруулсан.

Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл тайлбар 3 гарсныг холбогдох албан тушаалтнаас авч цахимд мэдээлсэн.

Байгууллагын шилэн дансны цахим мэдээлэлтэй холбоотой гарсан зөрчил, дутагдал байхгүй.

## 4. Хог хаягдлын хуулийн хэрэгжилт







Тус газраас 2023 оны 2 дугаар улирлын байдлаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Үүнд: Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин" бүрдүүлэх арга хэмжээний тухай 2023 оны 02 албан даалгаврын хүрээнд аймгийн хэмжээнд төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Хог хаягдал цэвэрлэх хүрээнд:** Аймаг, сумдын төвд нийтийн цэвэрлэгээг холбогдох шийдвэр, хуваарийн дагуу хийж байна.

**Сүмбэр сум:** Сумын хэмжээнд хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэж, нүхэнд түрж тэгшилэн ариутгаж булшлав. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр болон хувийн хэвшлийн 48 байгууллага 50 метр орчмын талбай, нийтийн эзэмшлийн хуваарьт талбайн цэвэрлэгээг 14 хоног тутам тогтмол зохион байгуулж ажиллаж байна. Цэвэрлэгээний үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, Хоггүй сүмбэр нэгдсэн групп ажиллуулж байна.

**Шивээговь сум:** Хоггүй сум зорилт дэвшүүлж, 27,500.0 мян.төгрөг Орон нутгийн хөгжлийн санд батлуулсан. Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 3/111 тоот албан бичгийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээний хуваарь гарган, цэвэрлэгээг зохион байгуулж, нийт 15 аж ахуй нэгж байгууллагын 45 ажилтан албан хаагч оролцсон. Нийт 4,8 га талбайн 4 тн хог хаягдлыг зөөж тээвэрлэн төв хогийн цэгт тээвэрлэсэн.

Шивээговь сумын 10 байгууллага ойр орчмын 50-100 м буюу нийт 2,8 га талбайн 2 тн хог цэвэрлэж, цэвэрлэсэн хог хаягдлаа ангилан 100 гаруй хуванцруудыг дахивар авах цэгт тушаасан.

Төвлөрсөн хогийн цэгийг булшлах, зооно татах ажлыг МАК компанитай хамтран зохион байгуулж, 4 га талбайн 32 тн хог хаягдлыг булж тэгшилсэн.

**Баянтал сум:** Сумын ЗДТГ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 74 тоот албан бичгийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээний хуваарь гаргаж, төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулан нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, нийт 6 тн хог хаягдлыг цэвэрлэн хогийн цэгт төвлөрүүлсэн

**Сэг зэм устгах арга хэмжээ:** Улсын чанартай авто зам дагуух мал амьтны сэг зэм болон хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сум тус бүр зохион байгуулсан.

**Сүмбэр сум:** “Саруул харгуй” ХХК-т хамтран улсын чанартай авто зам дагуу үхэж хорогдсон малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж, 4, 5, 6-р багийн нутаг дэвсгэрт үүссэн сэг зэмийг цэвэрлэж, 650 орчим бог мал, нийт 210 тн малын сэг зэмийг Мал эмнэлгийн газартай хамтран ариутгал халдваргүйтгэл хийж, булшилж дарсан. Энэхүү ажилд аймгийн Отрын бүсийн захиргаа, Ус-Ду ОНӨҮГ, Тохижилт Сүмбэр ОНӨҮГ, малчид хамтран, 3 техник хэрэгсэл 40 гаруй хүн ажилласан.

**Шивээговь сум:** Шивээговь сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/28 дугаар захирамжийн дагуу сэг зэм устгалын ажлыг маршрут гарган зохион байгуулсан. 5 албан хаагч, 2 туслах ажилтан, 2 техник хэрэгсэлтэйгээр нийт 700 километр явж, хонь 15, үхэр 9, адуу 7, ямаа 11, зээр 29, нийт 71 малын сэг зэмд халдваргүйжүүлэлт хийн булж устгасан.

**Баянтал сум**: Нийт 120 км газар буюу А/01, 01 зам дагуух хог болон 18, 16, 14 дүгээр зөрлөгүүд дээр байрлах хур хогыг цэвэрлэж ариутгасан.

**Уст цэгийн цэвэрлэгээ:** Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргаа, сум дундын Ойн анги, Тохижилт сүмбэр ОНӨҮГ-тай хамтран Усан сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс буюу Цоорхой рашаан, Чойрын богд ууланд 4 тн хог хаягдлыг цэвэрлэж, 3 машин, 1 хог ачигч машин, 15 хүн хамтран ажиллав.







**Мэдээлэл сургалт, сурталчилгаа:** Аж ахуйн нэгж байгууллагуудад хог хаягдлыг ангилан ялгаж хэвшүүлэх, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2022 оны 04 дүгээр хуралдаанаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам”-ыг таниулах, мөрдүүлэх зорилгоор Нийтийн номын сан, Боржигин өв музей, Биеийн тамир спортын газруудад Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах болон аймгийн хэмжээнд мөрдөгдөх журмын талаар сургалт, мэдээлэл хийсэн.

Сүмбэр сумын 2-р багийн Иргэдийн нийтийн хуралд “Орчны бохирдлыг бууруулах хүрээнд төрөөс хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, орон нутагт анхаарах зүйл, цаашдын хамтын ажиллагаа“ сэдвээр мэдээлэл өгч, хөрс бохирдуулагч нүхэн жорлонгоо өөрчлөх уриалгад иргэд нэгдэж, мэдээлэл солилцсон. Нийт 220 гаруй иргэд хамрагдсан.

Ерөнхий боловсролын сурагчдад хог хаягдлыг ангилан ялгаж хэвшүүлэх, гэр бүлийнхэндээ үлгэр жишээ үзүүлэх, бусдад нөлөөлөх, ангилсан хогоо дахиварт тушаах, хог хаягдлын хор уршиг, түүнийг багасгах арга замд сургах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтарсан удирдамжаар Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Зөв дадал, эерэг өөрчлөлт- Ногоон ирээдүй” сэдэвт хаврын аянг зарласан.




Ерөнхий боловсролын сурагчдад хог хаягдлыг ангилан ялгаж хэвшүүлэх, гэр бүлийнхэндээ үлгэр жишээ үзүүлэх, бусдад нөлөөлөх, ангилсан хогоо дахиварт тушаах, хог хаягдлын хор уршиг, түүнийг багасгах арга замд сургах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтарсан удирдамжаар Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Зөв дад ал, эерэг өөрчлөлт- Ногоон ирээдүй” сэдэвт хаврын аянг зарлаж, **Эко өртөө** арга хэмжээ зохион байгуулж байна. Энэхүү арга хэмжээнд БХНСАХЗ-аас 1333000 төгрөг зарцуулсан.

Эко өртөө арга хэмжээний зорилго нь Ерөнхий боловсролын сургууль, Политехникийн коллежийн Олон улсын Эко сургуулийн шалгуурыг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, Ерөнхий боловсролын сургуулиудын тогтвортой хөгжлийн боловсрол олгох хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагааг олон нийтэд түгээн сурталчлах, байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлаа багасгах, ангилан ялгах мэдлэг ойлголтыг өгч, зөв дадал хэвшлийг бий болгоход уриалах, байгальд ээлтэй амьдрах нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах.

ЭКО ӨРТӨӨ арга хэмжээг Политехникийн коллеж, Сүмбэр сумын 1, 5, Шивээговь сумын 3-р сургууль, Баянтал сумын 4-р сургуульд тус тус зохион байгуулсан. Арга хэмжээнд нийт 308 оюутан, сурагч, багш, ажилчид оролцсон.

Сүмбэр сумын 1-р сургууль, Шивээговь сумын 3-р сургууль нь Олон улсын Эко сургууль Ногоон туг хөтөлбөрт хамрагдахаар багш, ажилчид, сурагчид хичээнгүйлэн ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 56 дугаар албан бичгээр Худалдаа үйлчилгээний томоохон аж ахуй нэгжүүдэд нэгдсэн загвар бүхий ангилан ялгах хогийн сав байршуулах, Үүсэх хог хаягдлыг импортлогч нь хариуцах зарим бүтээгдэхүүнийг эргүүлэн худалдан авах, Аж ахуйн нэгж байгууллагын хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулж ажиллах

талаар сумдад чиглэл хүргүүлсний үр дүнд Биеийн тамир спортын газар, Нэгдсэн эмнэлэгийн гаднах нүхэн жорлонг буулгасан.





Баянтал сум нийтийн эзэмшлийн газар 10 байршилд ангилан ялгах хогийн сав байршуулсан

**Бусад арга хэмжээ**: Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Говьсүмбэр аймагт тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах чиглэлээр аймаг орон нутгаас зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтанд оролцож, хүрээлэн буй орчны доройтлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хамтран ажиллах чиглэлээр илтгэл тавьж, оролцогч компаниуд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхээр орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах Нийгмийн хариуцлагын гэрээ байгууллаа.

Сумдын Засаг дарга, байгаль орчны мэргэжилтнүүдийн цаашдын хамтын ажиллагаа, анхаарах асуудал сэдвээр уулзалт хийв. Уулзалтад сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга, Байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг албан хаагч хамрагдсан. Уулзалтын үр дүнд хог хаягдлыг бууруулах, цэвэр, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодит арга хэмжээ төлөвлөж, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга ойрын үеийн бодлого үйл ажиллагаа танилцуулж, үүрэг чиглэл өгч, хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулсан.

**Хог хаягдлыг ангилан ялгах, дахивар авах үйл ажиллагаа:**

Шивээговь суманд шинээр, Сүмбэр суманд 2 дахивар авах цэг ажиллаж байгаа бөгөөд Гялгар уут 5 тн, шил 30000 ширхэг, хуванцар 3 тн цуглуулан Улаанбаатарт боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.

**Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд:**

ТОПАС төхөөрөмж худалдан авсан өрхийн тоо 1, Хөрс бохирдуулахгүй доторлогоотой жорлонтой болсон аж ахуйн нэгжийн тоо 2, өрхийн тоо 5

Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор ус ашиглагч, хэрэглээг тоолууржуулах ажилд тогтмол хяналт тавьж, 2022 онд 9 аж ахуйн нэгж, байгууллага, 18 айл өрх шинээр цэвэр усны тоолуур, 3800 өрх цахилгааны ухаалаг тоолуур суурилуулсан бөгөөд эдгээрт хяналт тавьж ажиллаж байна.

Тус аймагт “Нарны цахилгаан станц” төслийг хэрэгжүүлж, төвийн бүсэд цахилгаан эрчим хүчийг нийлүүлж байна.

Хүнсний хаягдлаар био ялзмаг үйлдвэрлэж хэрэглэгчдэд байна. /сум дундын Ойн анги, Политехникийн коллеж, Нарны цахилгаан станц /

Ус ашиглагч байгууллагуудын ус ашиглалтын байдалд хяналт тавих зорилгоор Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргаатай хамтарч томоохон ус ашиглагч болох "Шивээ Овоо" ХК-ийн хүрэн нүүрсний уурхайн ус шүүрүүлэлтийн худгууд, "Эм Си Ти Ти" ХХК-ийн "Жонш баяжуулах үйлдвэр"-ийн худгуудад  лац тавьж ажилласан.

**ҮР ДҮН**:

1. Цэвэрлэсэн хог хаягдал:

| Сумын нэр | Хог хаягдал | Сэг зэм |
|---|---|---|
| Сүмбэр сум | 216240 тн | 210 тн |
| Шивээговь сум | 38 тн | 2 тн, 71 мал, амьтан |
| Баянтал  сум | 6 тн | 60  ал, амьтан |

2. "Нарны цахилгаан станц" төслийг хэрэгжүүлж, төвийн бүсэд цахилгаан эрчим хүчийг нийлүүлж байна.
3. Аюултай хог хаягдлын агуулахын барилга барьсан. /Ажлын тендерийг БОАЖЯ-нд зарлаж, Ажнай шарга ХХК гүйцэтгэгчээр шалгарч, барилгын ажлыг гүйцэтгэсэн./
4. Нөлөөллийн арга хэмжээ
   - Зохион байгуулсан сургалтын тоо: 10
   - Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж: 10 байгууллага, 767 иргэн
   - Тараасан гарын авлага: 1600
   - Зохион байгуулсан аян: Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй, Хүн бүр байгаль хамгаалагч, Эко өртөө
5. Даавуун уутны хэрэглээг нэмэгдүүлсэн. ЕБ-ийн 4 сургуулийн 200 гаруй багш, ажилчид даавуун уут тогтмол хэрглэж хэвшсэн.
6. Байгууллагын гадна ангилан ялгах хогийн сав байршуулсан аж ахуйн нэгж 15-аар нэмэгдсэн.
7. Гялгар уут 5 тн, шил 30000 ширхэг, хуванцар 3 тн цуглуулан Улаанбаатарт боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.
8. "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах" журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны ээлжит бус 10 дугаар хуралдаанаар оруулж батлуулсан.

**ЦААШИД АНХААРАХ:**

1. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын хэрэгжилтийг сайжруулах
2. Хог хаягдлыг ангилан ялгаж ачих талаар Тохижилт сүмбэр ОНӨҮГ-т зөвлөмж өгөх
3. Хог хяагдлыг ангилах ялган дадал хэвшил бий бөолгох, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулах хүрээнд үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах

**Аялал жуулчлал, усны салбарын төлөвлөлт, хэрэгжилт**

| № | Бодлогын бичиг баримт, төлөвлөгөө | Хяналтанд авсан зорилт, арга хэмжээний тоо | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр | 2 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ | 80 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажилллагааны хөтөлбөр | 6 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ | 70 |
| 3 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр | 3 арга хэмжээ | 80 |
| 4 | Аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө | 3 арга хэмжээ | 80 |
| 5 | Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт | | |
| 6 | Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт | 5 зорилтын хүрээнд 5 арга хэмжээ | 90 |
| 7 | Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт | 1 арга хэмжээ | 100 |

**Зохион байгуулсан, хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Усны нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр:

ААН, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “108 ойл” ХХК, “Аргал ойл” ХХК, “Петротрак” ХХК, ”И Эс Би Солар Энержи” ХХК, “Шинэ Монгол Магнетит” ХХК-ийн 2023 оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргасан.

Мөн иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Сүмбэр сумын 1 иргэн, Баянтал сумын 2 иргэнд цооног өрөмдөх зөвшөөрөл олгосон. Мөн Сүмбэр суманд үйл ажиллагаа явуулж буй “Адил Оч” ХХК-нд цооног өрөмдөх зөвшөөрөл олгож иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хугацаанд нь 100 хувь шийдвэрлэсэн.

УГГХДТСГЗ-тай хамтран аж ахуйн нэгж, байгууллагуудын ус ашиглалтын байдалд хяналт тавих зорилгоор ус ашиглагч “Шивээ Овоо” ХК, “Эм Си Ти Ти” ХХК-иудын худгуудад лац тавьсан. Мөн шинээр худаг гаргасан “Батганжир” ХХК, “Бас говь групп” ХХК-иудад баталгаат тоолуур суурилуулах зөвлөмж хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/176 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдсан “Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүн аймаг, сумдын усан хангамжийн эх үүсвэрүүдийн эрсдэлийг тодорхойлж Аймгийн ИТХ-ын 2023 лны 04 дүгээр тогтоолоор Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг батлуулсан.

“Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан Ерөнхий боловсролын 5-р сургуулийн 7 дугаар ангийн нийт 64 сурагчдад “Өөрчлөлтийг хурдасгая. Усны зохистой хэрэглээ” сэдэвт сургалт зохион байгуулсан. Мөн аймгийн Музей, Нийтийн номын сан, Биеийн тамир, спортын газрын 27 иргэнд “Усны зохистой хэрэглээ” сургалтыг зохион байгуулсан. Говьсүмбэр аймгийн эмэгтэйчүүдийн “Оюу” клубтай хамтран Сүмбэр сумын 4-р багийн малчин эмэгтэйчүүдэд усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр сургалт, ярилцлага зохион байгуулж 13 малчид хамрагдсан.

Аймгийн 2023 оны БХНСАХЗ-ын 19.9 сая төгрөгийн хөрөнгөөр уруйн үерийн улмаас 2022-2023 онд эвдрэлд орсон Сүмбэр сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Цоорхойн рашаан, Уулзварын гол, Асгана булгийн хамгаалалтын хашааг сэргээн засварлах ажлыг

гүйцэтгэхээр “Жавхлант Аривжих” ХХК-тай гэрээ байгуулж ажлын гүйцэтгэл 40 хувьтай хийгдэж байна.

Мөн аймгийн БХНСАХЗ-ын 7.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 5 дугаар багт байрлах Хөндлөн булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг тухайн булгийн ойролцоо нутагладаг “Хүхээгийн гол” малчдын бүлэгтэй гэрээ байгуулж хашаажуулах ажлын гүйцэтгэл 30 хувь хийгдэж байна.

УГГХДТСГЗ-тай байгуулсан гэрээний дагуу Говьсүмбэр аймгийн усан хангамжийн эх үүсвэр, усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох судалгааны ажлыг хийж гүйцэтгэн нийт усан хангамжийн эх үүсвэрийн 9 худаг, Сүмбэр сумын 22 уст цэг, Шивээговь сумын 16 уст цэгт хамгаалалтын бүс тогтоох зураглал үйлдэж Уул уурхайн яам болон Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас санал авахаар албан бичиг хүргүүлээд байна.

Аймгийн хүн амын усан хангамжийн эх үүсвэр болох Тэрэгтийн газрын доорх усны орд газарт байрлах айл өрхүүдэд хөрс бохирдуулдаггүй нүхэн жорлонтой болох талаар гарын авлага, мэдээлэл тарааж эх үүсвэрт байх айл өрхүүдийг “Жорлонгоо өөрчлөе” аянд хамруулсан.

Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2023 оны А/305 дугаартай албан бичгээр 2024 онд ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг БОАЖЯ-нд хүргүүлсэн.

Мөн 2024 онд ашиглах байгалийн нөөцийн орлогын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хуулийн хугацаанд Байгаль орчны мэдээллийн сангийн Байгаль орчныг хамгаалах төсөв зардлын мэдээллийн санд оруулсан.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө дутуу гүйцэтгэлтэй ажлууд

| № | Арга хэмжээ | Хугацаа |
|---|---|---|
| 1. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийлгүүлэх | 11 сарын 30-ны дотор |
| 2. | Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасны дагуу усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг ИТХ-аар тогтоож, Хууль зүйн яаманд бүртгүүлж, дэглэмийг мөрдүүлж, тэмдэгжүүлэх | 11 сарын 30-ны дотор |
| 3. | Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийх | 10 сарын 30-ны дотор |
| 4. | Аймаг сумдын төвийн ундны усны эх үүсвэрт нөөцийн судалгаа хийхэд шаардлагатай санал боловсруулж БОАЖЯаманд хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах | 10 сарын 20-ны дотор |

Сайдтай байгуулсан гэрээний биелэлт

| № | Арга хэмжээ | Хугацаа |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| 1. | Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх | 10 сарын 30-ны дотор |
| 2. | Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах зорилгоор гадаргын усны тоо бүртгэл зохион байгуулах | 10 сарын 20-ны дотор |

Статистик мэдээлэл

| № | Шалгуур | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|---|
| 1 | "E-Mongolia" цахим үйлчилгээний хамрагдалт | 0 | 0 | 8 | 4 |
| 3 | Уул уурхайн нөхөн сэргээлт /га/ | 7.3 | 3.8 | 4.5 | 3 |
| 4 | Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт | 2 | 3.1 | 4.1 | |
| 5 | Хур хог хаягдалтай талбайн нөхөн сэргээлт | | | 11.4 | |
| 6 | Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь | | 84.6 | 85 | 85 |
| 7 | Хашиж хамгаалсан булаг шанд | 1 | 2 | 1 | 1 |
| 8 | Цооног өрөмдөх зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгж | 6 | 3 | 9 | 4 |
| 9 | Усны асуудлын хүрээнд хийгдсэн судалгаа | 1 | 0 | 0 | 1 |
| 10 | Гадаргын усны тооллого | 479 | 521 | 532 | 545 |
| 11 | БХНСАХ-ийн зардлаас усны салбарт зарцуулсан зардал /сая.төг/ | 68.5 | 51.7 | 68.6 | 84.3 |

Ололт, амжилт:

Төлөвлөлт сайн. Төлөвлөсөн ажлууд сайн гүйцэтгэсэн.

Зөвлөмж:

1. Шинэлэг ажил санаачилан эхэржгүүлэх
2. Тайлагналтыг сайжруулах

Албан тушаал: Аялал жуулчлал, Тусгай хамгаалалттай газар, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

| № | Бодлогын бичиг баримт, төлөвлөгөө | Хяналтанд авсан зорилт, арга хэмжээний тоо | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажилллагааны хөтөлбөр | 1 зорилт<br>1 арга хэмжээ | 80 |
| 2 | Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажилллагааны хөтөлбөр | 6 зорилт<br>6 арга хэмжээ | 70 |
| 3 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр | 1 зорилт<br>1 арга хэмжээ | 90 |
| 4 | Аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө | 5 зорилт<br>5 арга хэмжээ | 60 |
| 5 | Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх<br>таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт | - | |
| 6 | Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх<br>таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт | 5 зорилт<br>5 арга хэмжээ | 60 |
| 7 | Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт | - | |

**Зохион байгуулсан, хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

1. Зочлох үйлчилгээний салбарын аж ахуй нэгж байгууллага, иргэдэд **“Аялал жуулчлалын салбарт зочлох үйлчилгээний байгууллагуудын хамтын ажиллагаа**” уулзалтыг 2023 оны 03 сарын 03-ны өдөр сургалтын танхимд зохион байгуулсан.
2. Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монгол зочлох жил” болгон зарласантай холбогдулан 21 аймагт Welcome to Mongolia самбар байршуулах үүргийн дагуу хуучин цагдаагийн постны ард байрлах самбарт орон нутгийн BNZ зургийн студи, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хөрөнгө оруулалтаар хэвлүүлж, Онцгой байдлын газраас тогтоолгосон. Самбарыг 2 удаа байршуулсан.
3. **Аялал жуулчлал ба орон нутгийн нөөц боломж**” сэдэвт орон нутгийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн тур операторуудтай хамтарсан зөвлөлдөх уулзалтын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан, Говьсүмбэр аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 2023 оны арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд төрийн бус

байгууллагуудтай хамтран ажиллах, түншлэлийн холбоог сайжруулж, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх санал санаачлагыг дэмжих арга хэмжээний хүрээнд орон нутгийн аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, аялалын маршруттай танилцаж, түүх, соёл, дурсгалт газрууд болон аймаг орон нутагт зохион байгуулагдах эвент арга хэмжээг сурталчлах, тур операторуудтай хамтран ажиллах, түншлэлийн холбоог сайжруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын газар Аялал жуулчлалын холбоо, Боржигин голомт жуулчны бааз,Тур оператор 18 кампани, Оорцог элгэн Хоршоотой хамтран Боржигин голомт жуулчны баазад 2023 оны 06 дугаар сарын 3-10, 11өдрүүдэд зохион байгуулсан

***Үндэслэл:*** Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/41 дүгээр захирамжийн 10 дугаар хавсралтаар батлагдсан Аялал жуулчлалыг 2023 онд хөгжүүлэх төлөвлөгөөний 6.15 дугаар арга хэмжээ 1,000,000.0 төгрөгийг зарцуулав.

**Ололт, амжилт:** Тур оператор байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулан, холбогдох тур операторуудтай жуулчны бааз, үйлчилгээний газруудыг танилцуулж, харилцаа тогтоож, цаашид ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх , аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, боломжийг нээсэн. Орон нутгийн түүхэн дурсгалт газрууд болон үзмэр, үйлчилгээ, Боржигин өв соёл, Боржигин Уртын дуу, Боржигин умарзай, Боржигин цайны ёсыг танилцуулсан.

**Зөвлөмж:**

1. Маш хурдтай ажлуудын удирдамжийг гаргаж, хурдтай ажиллах, мэргэжлийн хүмүүсээс илүү дэлгэрэнгүй зөвлөгөө авч салбарын мэдээ мэдээллийг, сурталчлах шаардлагатай.
2. Бичиг баримт боловсруулалтыг сайжруулах
3. Тайлан мэдээг үнэн зөв оновчтой тайлагнах
4. Шинийг санаачлах

Тайлан нэгтгэсэн: Ахлах мэргэжилтэн Б.Гандулам